

УЛС ТӨР

Ц.ДУЛАМСҮРЭН: АВТОМАШИН ХҮРЭХ БОЛОМЖГҮЙ ГАЗАР УСАА 20-30 ЛИТРЭЭР НЬ ЗӨӨЛӨӨ

II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛЫН ЖУДОГИЙН ТАМИРЧДЫГ ГУТААН ДОРМЖИЛСОНД ХАРАМСЧ БАЙНА ГЭВ

III нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Дугаарын 60 мөр

Богд уулыг ашиглаж болно, хамгаалахаа бүү март

Н.БАТЗАЯА

Цай нь олширч, авьяа нь цөөдсөн хаврын чуулган

Хэрэв та мэдээ үздэг бол холбогдох мэргэжилтнүүдийн өнгөрсөн нүрвэ гарагт хийсэн гал түймрийн талаархи мэдээллийг сонссон болов уу. Монгол Улсын Шадар сайд, Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа, ОБЕГ, ЦУОШГ хамтран “Богд ууланд асч байсан зургаан түймрийн дөрвийг нь бүрэн унтрааж, хоёрыг нь цурманд оруулсан. Бороо оролгүй удсан учраас хөрсөн доогуур шатаж байхыг ч үгүйсгэхгүй. Энэ сарын 22-нд ой хээрийн түймэрт зориулж үүл буудна” гэх мэдээлэл хийсэн. Хамгийн харамсалтай нь ууланд гарсан ихэнх түймрийн шалтгаан нь иргэний буруутай үйл ажиллагаатай холбоотой гэнэ. Тухайлбал, ууланд аялахаар очсон иргэд цай чанаж уух гэж байгаа нь энэ гээд гэрийн буйрын чинээ гал алдчихсан тохиолдол ч байдаг тухай холбогдох албаныхан анхааруулаад авна билээ.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ДЭЛХИЙ

Лондонгийн барилгад гал гарч, В.ПУТИН ИРГЭДТЭЙГЭЭ “ШУУД ЯРИЛЦСАН” ДОЛОО ХОНОГ

Б.ДАВААХҮҮ

Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа өрнөсөн онцлох үйл явдлыг тойллон хүргэж байна.

В.Путин 15 дахь удаагийн шууд ярилцлагаа хийв

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин жил бүр “В.Путинтай хийх шууд ярилцлага” сэдэвт телевизийн шууд нэвтрүүлэгт оролцож,

ард түмнийхээ тавьсан асуултад хариулдаг уламжлалтай. Энэ удаад тэрбээр 15 дахь удаагаа телевизийн эфирээр иргэдтэйгээ нээлттэй ярилцсан нь энэ юм. Шууд ярилцлага өнгөрөгч баасан гарагт болсон бөгөөд энэ үеэр Ерөнхийлөгч В.Путин улс орны эдийн засгийн байдал нь Оросын иргэдийн аж амьдралд хэрхэн нөлөөлж байгаа, хямралыг хэрхэн даван туулах, АНУ болон Европын орнуудын тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээ, хөдөө аж ахуй хийгээд хувийн амьдралынхаа талаар ч сонирхсон асуултад хариулт өгсөн байна.

Үргэлжлэл нь VI нүүрт

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ҮҮЛДРИЙН ХОНИОР МАЛЫН ГЕНЕФОНДОО АРВИЖУУЛАХ НЬ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Б.СУМБЯА

“Air Cargo Global” OM-ACG загварын нисэх онгоц “Чингис хаан” нисэх онгоцны буудлын

карго терминалын орчимд бямба гарагийн орой 19.00 цагийн орчимд газардлаа. Нисэх онгоцны хүнгэнэх чимээ ойр орчимд тархаж, тусгай

хувцастай нисэх буудлын ажилтнууд ачаа хүлээн авах бэлтгэлээ хийх аж. Тэрхүү онгоцонд чухал “ачаа” бий.

Үргэлжлэл нь IV нүүрт

19 ДЭХ ЖИЛДЭЭ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

Захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2358.00	2374.00	ФУНТ	2964.00
ЕВРО	2593.00	2673.00	РУБЛЬ	39.80
ИЕН	21.09	21.51	ЮАНЬ	344.50

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2355.00	2372.00	ФУНТ	2956.00
ЕВРО	2586.00	2692.00	РУБЛЬ	38.80
ИЕН	20.76	21.69	ЮАНЬ	344.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Өнөөдөр 20 мянган ажлын байрыг нээлттэй зарлана

Г.ЧИМЭГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нээлттэй хаалганы өдөрлөг өнөөдөр болно. Монгол Улсын 865 мянган өрх, гурван сая гаруй иргэнд хүрч үйлчилдэг тус салбарынхан хоёр өдрийн турш нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүн амын хөгжил, нийгмийн халамжийн олон талт бодлого, хууль эрх зүйн орчноо танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, зарим нэг үйлчилгээг газар дээр нь үзүүлэхээр төлөвлөжээ. Энэхүү өдөрлөг 21 аймагт нэгэн зэрэг зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм. Тиймээс хамгийн том Хөдөлмөрийн бирж энэ хоёр өдөрт ажиллаж, 20 мянган ажлын байрны бүртгэл явагдах нь. Өдөрлөгөөр дамжуулан 60 орчим ААН нээлттэй ажлын байраа зарлажээ. Мөн Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг зөв зохистой зарцуулах зорилгоор хэрэгжүүлж буй эмчилгээ оношлогооны үнийн чөлөөлөлт, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой аж.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Б.ТОГТОХ

Сүүлийн өдрүүдэд Богдхан ууланд олон удаагийн гал түймэр гарч, багагүй хохирол учраад буй. Энэ талаар Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэнгээс тодрууллаа.

-Богдхан ууланд хэд хэдэн түймэрч гарч, байгаль хамгаалагчид болон онцгойгийнхон газар дээр нь олон хоног ажилласан. Түймрийг цурманд оруулж чадсан уу?

-Голдуу явган аялагчдын маршрутын замын дагуу ойр ойрхон таван түймэр гарсан. Одоогийн байдлаар Залаатын амны түймрийг онцгойгийнхон унтраагаад цурман дээр нь манайхан ажиллаж байгаа. Уулын түймрийн аюултай нь модны ёроолоор үргэлжилдэг. Өдөр нь ус асгаад унтраалаа

...Бидний зүгээс хуурайшилтын үед явган аялахыг зогсоох удирдамжийг баримтлан ажиллаж байна. Нийслэлчүүдийн хувьд явган аялах хамгийн ойр газар нь Богдхан уул. Гэхдээ гал түлж, тамхи татах гэх мэт буруу үйлдлүүдийг ихээр хийдэг нь асуудал болж байна...

Ц.ДУЛАМСҮРЭН: АВТОМАШИН ДУРХ БОЛОМЖГҮЙ ГАЗАР УСАА 20-30 ЛИТРЭЭР НЬ 300000



гэхэд доогуураа шатаж байгаад маргааш нь өөр газраар гараад ирдэг. Тиймээс хүн хүч, эдийн засгийн хүндрэл гарсан. Тухайлбал, Богдын дархан цаазат хамгаалалтын захиргаа зургаан мэргэжилтэн, нэг жоолооч, 23 ойн хамгаалагчтай. Ийм бүрэлдэхүүнээр түймрийг гарсан даруйд нь шуурхай дарж авах боломжгүй.

-Түймэр явган аялагчдын маршрутын замын дагуу гарч байна гэлээ. Үүнийг зогсоохын тулд ямар арга хэмжээ авч байгаа вэ?

-Бидний зүгээс хуурайшилтын үед явган аялахыг зогсоох

удирдамжийг баримтлан ажиллаж байна. Нийслэлчүүдийн хувьд явган аялах хамгийн ойр газар нь Богдхан уул. Гэхдээ гал түлж, тамхи татах гэх мэт буруу үйлдлүүдийг ихээр хийдэг нь асуудал болж байна. Үүнтэй холбогдуулан тавдугаар сарын 9-нд тушаал гараад явган аялагчдыг хуурайшилтын үед аялахыг зогсоосон. Гэвч аялагчдын хөл тасраагүй. Иргэдийн зүгээс "Бид яагаад аялж болдоггүй юм, би гал түймэр тавихгүй" гэдэг. Гэвч ууланд гарсан даруйдаа гал алдсан тохиолдол олон гарч байна. Бидний хувьд үүнээс

сэргийлж, ээлжийн жижүүр гарган ажиллаж эхэлсэн. **-Хуурайшилт цааш үргэлжилбэл, нөхцөл байдал улам хүндрэх магадлалтай юм байна. Газар дээр нь ажиллаж байгаа хүний хувьд цаашин галт түймрийн аюулаас сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ?**

-Энэ хавар үндсэндээ Богд ууланд арван түймэр гарсан. Сүүлийн гурван түймрийн голомт дээр манай байгууллагын бүх ажилчид өдөр шөнөгүй ажиллаж цурманд оруулсан. Нэг хэсэг нь ус зөөж авирсан бол нөгөө хэсэг голомт дээр

ажиллах жишээтэй. Сүүлдээ зарим хүмүүсийн бие нь муудаад эмнэлэгт хэвтсэн тохиолдол ч бий. Онцгойгийнхон гол хүч болж байна. Онцгой байдлын автомашин ирээд ч хүрэхгүй газрууд байгаа шүү дээ. Тиймээс 2-3 км-ийн цаанаас 20-30 литрээр нь ус зөөсөн. **-Тусгай хамгаалалттай газрыг хариуцсан яам тамгын газрууд байгаа. Тэдний зүгээс дэмжлэг үзүүлж байгаа юу?**

-Салбарын яамнаас тухай бүрт дэмжлэг үзүүлээд явж байна. Саяхан л гэхэд БОАЖ-ын сайд Д.Оюунхоролын тушаалаар Хан Хэнтийн дархан цаазат газар, ма-

най хоёрт тус бүр 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүгээр албан хаагчдын хоол хүнс, техник хэрэгслийн шатахууны хэрэгцээг шийдвэрлэж байна. Ер нь яам тодорхой хэмжээнд ард иргэдийнхээ төлөө чиглэсэн олон ажил хийж байгаа. Үүний нэг нь Цэцээ гүний явган аяллын маршрутыг 10 сая төгрөг гаргаж янзалж өглөө. Мөн Зайсанд автомашины зогсоол, аялагчдын амрах газар гэх мэтээр иж бүрэн тохижуулахаар ажиллаж байна. Эдгээр асуудлыг шийдэж чадвал, аялагчид зориулалтын газраа амраад гал түймрийн эрсдэл төдий чинээгээр буурна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Бодлогын хүү хоёр хувиар буурлаа

Г.ГАНАА

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл өнгөрсөн долоо хоногийн сүүлчээр хуралдаж, бодлогын хүүг хоёр хувиар бууруулж 12 хувь болгох, бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +2, -2 нэгж хувийн өргөнөөр тэгш хэмтэйгээр шинэчлэн тогтоох шийдвэр гаргалаа. Инфляци өнгөрсөн сарын байдлаар улсын хэмжээнд жилийн 3.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд жилийн 3.8 хувьд хүрчээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Утааны голомтод амьдарч байгаа иргэдийг ипотекийн зээлээр дэмжинэ гэв

Г.ГАНЧИМЭГ

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулахын тулд I, II бүсэд оршин суугчдыг орон сууцны ипотекийн зээлд урьдчилгаа төлбөргүйгээр хамруулахаар шийджээ. Улаанбаатар хотын хамгийн өндөр агаарын бохирдолтой буюу I, II бүсийн нутаг дэвсгэрт амьдарч буй 183 мянган өрх ипотекийн зээлд хамрагдахдаа урьдчилгаа төлбөрөө Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах орон сууцны сангийн дэмжлэгийг авч, урьдчилгаагаа бүрэн төлүүлэх боломжтой аж.

Агаарын чанарыг сайжруулах I бүсэд Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн 51 хорооны 131 мянган өрх, II бүсэд Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргийн 52 мянган өрх буй юм байна. Эдгээр бүс нутагт байрлах Баянхошуу, МҮОНРТ, 100 айл орчмын агаар дахь хүхрийн давхар исэл /SO2/ нарийн ширхэгт тоосонцор /PM2.5/-ын агууламжийн хэмжээ агаарын чанарын стандартаас 10-30 давсан тохиолдол удаа дараа бүртгэгдэж байсан бөгөөд Улаанбаатар хотын агаарын бохирдлын голомт юм.

Гэр хорооллын бүсээс ипотекийн зээлд хамрагдаж буй иргэд нүүхдээ хашаа байшингаа дараагийн иргэнд худалдаж,



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

орон сууцанд амьдарч буй иргэд ипотекийн зээлд хамрагдаж гэх мэт байдал түгээмэл байгаа нь агаарын бохирдлын голомтод амьдарч буй иргэдэд чиглэсэн үр дүнтэй бодлого боловсруулах шаардлагыг бий болгоод байгаа юм. Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Нийслэлийн Засаг дарга С.Багболд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах орон сууцны санг санаачлан байгуулж буйгаа мэдэгдсэн юм. Улаанбаатар хотын захирагч С.Багболд "Агаарын бохирдол хамгийн ихтэй I, II бүсийн яндангийн тоог бууруулах замаар агаарын бохирдолтой бодитой тэмцэнэ. Орон сууцны урьдчилгаа төлбөр төлөх боломжгүй иргэдэд ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг сангаас төлөх замаар зорилтот иргэдийг хямд өртөгтэй, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулах юм. Ингэснээр зогсонги байдалд

Инфляцийн өсөлтөд эдийн засгийн сэргэлтээс гадна нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс нөлөөлж буй аж. Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хэрэгжүүлсэн мөнгө, төсвийн бодлогын арга хэмжээ болон ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн нөлөөгөөр макро эдийн засгийн эрсдэл буурч,

тодорхой бус байдал багасч, зах зээлд оролцогчдын итгэл сэргэж буй юм. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалт эрчимжиж, гадаад худалдааны нөхцөл сайжирсан, богино хугацаат гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт буурч байгаа зэрэг нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байгаа аж. Иймд инфляцийг

дунд хугацаанд тогтворжуулах зорилт алдагдахааргүй байгаа тул мөнгөний бодлогыг зөвлөрүүлэх энэхүү шийдвэр нь эдийн засгийн өсөлт, бизнесийн идэвхжил, ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ хэмээн Мөнгөний бодлогын зөвлөл үзэж байна.

Багшийн хөгжлийн тухай хуулийн төслийг өргөн барив

УИХ-ын дарга М.Энхболдод өнгөрсөн пүрэв гарагт Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк байгуулах болон банкны үйл ажиллагааны тухай 1963 оны аравдугаар сарын 22-ны өдрийн хэлэлцээр, Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2014 оны протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатар өргөн мэдүүлжээ. Монгол Улс нь Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (ЭЗХАОУБ)-ны гишүүн улсын хувьд Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк байгуулах, банкны үйл ажиллагааны тухай 1963 оны аравдугаар сарын 22-ны өдрийн хэлэлцээр болон Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2014 оны протоколыг хүлээн зөвшөөрч, гишүүний эрхээ хадгалах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн энэ өдөр Г.Чулуунбаатар сайд "Монгол Улсын 2016 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг өргөн бариллаа. Төсвийн тухай хуулийн наймдугаар зүйлд "УИХ нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах" гэж заасан байдаг ажээ. Үүнтэй холбоотойгоор УИХ-ын гишүүн Н.Учрал Багшийн хөгжлийн тухай хуулийн төслийг УИХ-ын дарга М.Энхболдод өргөн барив. Энэ үеэр УИХ-ын гишүүн Н.Учрал "Боловсролын үйл ажиллагааг хэвийн жигд явуулах нөхцөл орчин бүрдүүлэх, багшийн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлж, багшийн хөдөлмөрийг бодитоор үнэлэх", эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно" гэж заасан нь хуулийн төслийг боловсруулах эрхзүйн үндэслэл болсон хэмээн тайлбарлалаа.

ҮЗЭЛ БОДОЛ

ГАЙ НЬ ОЛШИРЧ, ГАВЬЯА НЬ ЦӨӨДСӨН ХАВРЫН ЧУУЛГАН

Дугаарын 60 мөр

Богд уулыг ашиглаж болно, хамгаалахаа бүү март

Б.ӨНӨРТӨГТОХ

М.Энхболдын тэргүүлсэн парламентын анхны хаврын чуулган энэ оны дөрөвдүгээр сарын 5 буюу билгийн тооллын хаврын дунд харачин туулай сарын шинийн 9-ний найралт одтой өдөр нээлтээ хийснээс хойш хэдийнэ хоёр сарын гаруйн хугацаа өнгөрчээ. Билэгт сайн өдөр нээлтээ хийсэн хаврын чуулганы завсарлах хугацаа хараахан болоогүй ч, орон даяар Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа эхэлж, улс төрийн намууд нэр дэвшигчээ тойроод завгүй байгаа учраас өнгөрөгч лхагва гарагт буюу зургадугаар сарын 14-нд УИХ-ын чуулганыг түр завсарлуулах захирамжид М.Энхболд дарга гарын үсэг зурав. Чуулган энэ сарын 28-нд буюу Монгол Улсын тавдахь Ерөнхийлөгч сонгогдсоны дараа эргэн хуралдаж, Төрийн тэргүүний тангараг өргөх ёслолыг зохион байгуулах учиртай. Мөн хэлэлцэж амжилгүй үлдсэн бусад хуулийн төслүүдээ хэлэлцэж, улмаар Улсын баяр наадмын өмнөх нэгдсэн байдлаар завсарлах билээ. Гэвч улс төрийн өнөөгийн нөхцөл байдал, сонгуулийн дараах нөхцөл байдал зэргээс харахад наадмын өмнөх чуулган хэзээ ч үр дүнтэй байдаггүй. Ялагдсан нь ялагдлаа хүлээн зөвшөөрөх, ялсан нэгнийг баталгаажуулах асуудал удаан хугацаанд маргаан

түүвэрлэсэн иргэд Үндсэн хуулийн төрчлөх эсэх асуудлаар санал өгч, эдгээрээс 700 гаруйг нь Төрийн ордонд хэлэлцүүлэгт урьсан билээ. Тэдэн дунд бичиг үсэггүй хүн ч байв. Энэ хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжийг УИХ-д хүргүүлж, Ард нийтийн санал асуулгаар Ерөнхийлөгчийн сонгуультай хамт санал асуулга явуулах санаархал ч УИХ-ын хаврын чуулганы үеэр яригдав. Хэтэрхий цаг нь тулчихсан, ямар ч тооцоогүй, 1500-хан хүний саналд үндэслэн “эцэг” хуулиараа оролдох нь намын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх нь гэдгийг эрх баригчид ухаарч, энэ асуудлыг Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа үргэлжлүүлэхээр шийдэлд хүрчээ. Өөрөөр хэлбэл, ард түмний дунд бүтэн сарын

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах асуудлаар УИХ-ын 29 дүгээр тогтоол гэгчийг батлах үед 11 дүгээр заалтад Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй компаниуд олсон ашгаа дотоодын банкаар дамжуулах тухай заалтыг тусгаж өгсөн юм. Эдийн засгийн асар том боломж, Төв банкны валютын сангийн нөөцийг нэмэгдүүлэх чухал заалтыг ОУВС эсэргүүцэж, санхүүжилт олгохоос татгалзсан. Энэ нь Оюутолгойн хүсэлт гэдэг нь хэнд ч илхэн байсан. Гэтэл Сангийн сайд яаран сайдрэн өөрөө энэ заалтад завсар хийн УИХ-аар хэлэлцүүлэхээр оруулж ирсэн. Тавдугаар сарын 04-ны өдрийн чуулганаар 29 дүгээр тогтоолыг өөрчлөх 30 дугаар тогтоол гэгчийг УИХ шөнөөр хэлэлцэж баталж

Үүнээс болж олон зуун иргэд хохирч, харин ченжүүд завшаад өнгөрлөө. Төв банкинд хийсэн шалгалтын дүнгээс болж мөн л МАН, АН хоёр удтал маргалдаж, идсэн ууснаа илчилсээр хаврыг барлаа. Хамгийн сүүлд УИХ анх удаа нэг хүнийг онилсон ялын тогтоол баталж, олон зуун аж ахуйн нэгжүүдийг шоронд илгээх тогтоол баталсан юм. Нэг сайдаа огцруулж, даргын цүнх барьж явсан цөөнгүй хүмүүст Элчин сайдын суудаар бэлэг барив. Мөн Б.Жавхлан нарын гишүүд Хөрөнгө оруулалтын банк нэрээр гадны банк санхүүгийн байгууллага оруулж ирэхээр санаархсан ч Ерөнхийлөгчийн эсэргүүцэлтэй тулгарснаар мөн л хуулийн төсөл нь гацаанд оржээ.

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Уг нь Богд уул Монгол Улсын төдийгүй дэлхийн дархан цаазат газруудын нэг. 1778 онд Монголын эхээтнүүдийн нэг сайд Юндэндоржийн санаачилгаар Богд хан уулыг дархан цаазтай болгосон түүхтэй гэдэг. Гэвч улс орон хөгжихийн хэрээр хүмүүс байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахаас илүү гэр бүл, найз нөхдөөрөө аялал зугаалганд явж, зургаа авахуулан хорхог, боодог хийхийг илүүд үзэх болжээ. Түүнээс болж хог тарих, цаашлаад гал түймэр хүртэл тавьж улсын тусгай хамгаалалттай газрыг сүйтгэж байна. Ялангуяа Нийслэлчүүд Богд уулын хамгийн өндөр оргил гэгдэх 2268 метрийн өндөртэй Ицээ гүний оргил, Зайсан толгой, Их тэнгэрийн ам гэх мэтчилэн хэд хэдэн чиглэлээр алхалт хийдэг. Яах вэ, аялал зугаалганд явж, эрүүл мэнддээ анхаарал тавьж болно.

Сөрөг хүчин онц дүн авлаа

Энэ мэтээр өнгөрсөн хаврын чуулганаас олонтой үр дүн харагдсангүй. Хэт их ажилласан ч хийсэн гавьяа дулимаг хаврын гурван сарыг үджээ, тэд. Чуулганы нээлтийн үеэр амлаж байсан шиг эдийн засгаа хямралаас гаргаж, энгийн тасагт хэвтүүлж чадсангүй. Өр тавьж, төсвийн алдагдлаа нөхсөн, өмнөх зээлээс давуулж авсан мөнгөөрөө эдийн засгаа сэргээх бус сонгуулийн амлагт өгснийг эс тооцвол энэ парламентаас гялтайх мэдээ ховорхон дуудав. Гэвч сайны хажуугаар саар гэгчээр ганц нэгхэн чухал хууль хаврын чуулганы хэрүүл дундуур батлагджээ. Тодруулбал, Ц.Цогзолмаа, Д.Сарангэралнарын гишүүдийн өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтоолын төслийг баталж чадлаа. Н.Номтойбаяр нарын залуу гишүүдийн дэмжлэгээр залуучууд анх удаа бие даасан хуультай болов. Хог хаягдлын тухай хуулийн төслөө шинэчилж чадсанаар аюултай хог хаягдлаа эмхлэх, үнэгүйдсэн баялаг гэгдэх хог хаягдлыг дахин ашиглах асуудлаар нэг шат урагшлав. Маргаан мэтгэлцээнтэй ч Зөрчил, Эрүүгийн хуулиа баталж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчил шалган шийдвэрлэх зэрэг хуулиудыг тус тус баталж чадлаа.

Энэ мэтээр нийгмийн анхаарал татсан, хүлээлт үүсгэсэн хуулийг цөөнгүй баталсныг нь үгүйсгэж болохгүй. Харамсалтай нь энэ бүх гавьяагаа гаХаврын чуулганы амжилт, алдааг бичихдээ сөрөг хүчний оролцоог дурьдахгүй өнгөрч боломгүй. Хэдийгээр парламентад есон суудал авсан ч АН-ынхан хаврын чуулганаар улс төрийн сөрөг хүчин шиг зангартагтай ажиллаж чадлаа. Хатуухан хэлэхэд, олонхийн гишүүдийн өмнөөс ажлыг нь хийж, УИХ-аар хэлэлцэж буй олон ч хуулийн төслөөр хэлэлцүүлэг өрнүүлсэн. Төрийн албаны чадамж, Эрүүгийн хууль гэх мэтээр анхаарал татсан хуулиудаар тэд хэлэлцүүлэг өрнүүлж, өөрсдийн болон иргэдийн байр суурийг МАН-ыханд хүргүүлж байв. Мөн шаардлагатай сэдвээр тухай бүр нь байр сууриа илэрхийлж, Төв банкны асуудалд ч аль нэг талыг бус эдийн засгийн бодит үр дүн, бодлогын шинжтэй байр суурь илэрхийлж байсан нь олон нийтийн талархлыг хүлээж, ард түмнээс тэд “А” үнэлгээ авч чадлаа.



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

дагуулдаг учраас наадмын өмнөх долоо хоногийн чуулган ёс төдий хуралдсан нэр зүүгээд л өнгөрдөг жамтай. Харин наадмын маргаашнаас улс төрчид тойргийнхоо аймаг сумын ой, даншиг наадмууд хэсч, айраг цагаа эргүүлж оддог учраас энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудал үндэсэндээ өнгөрсөн лхагва гарагаар дуусгавар боллоо гэж хэлж болно. Тиймдээ ч хаврын чуулганы үр дүн юу байсан, хэлэлцэх асуудлаа бүрэн дуусгасан эсэх, анхаарал татсан сэдэв юу байсныг өнөөдрийн нийтлэлээр онцлоё.

хугацаанд хэлэлцүүлэг өрнүүлж, улмаар наадмын дараа ээлжит бус чуулган зарлаж асуудлыг хэлэлцэхээр болов.

Эргэж хургасан шийдвэр, сайтар судлаагүй хуулиуд

Өнөө жилийн хаврын чуулганаар баталсан дийлэнх хууль хамгийн их хэл ам дагуулж байсан гэхэд хэтийдэгүй. Парламентын олонхи гишүүд нь “бор халзан хонинууд”-аас бүрдсэн учраас арга ч үгүй. Тэд дөнгөж эхний жилээ УИХ-д сууж байгаа атлаа олон том хуулийн автор болж, энэ нь эргээд МАН-ыг муухай харагдуулж байсан гэхэд болно. Өнөөгийн парламентад 65 суудал авсан атлаа МАН-ын тун цөөхөн гишүүн хуулийн төсөл өргөн барьсан. Тэр тусмаа залуу гишүүдээрээ хаврын турш “тут тахив”. Хууль шүүхийн байгууллагын асуудал болгоныг Х.Нямбаатар өргөн барьж, төсөв, мөнгөний асуудлаар Т.Аюурсайхан, Б.Чойжилсүрэн хоёр л дуугарах жишээтэй. Ардчилсан парламент бүрдсэн 20 гаруй жилийн түүхэнд баталсан хууль болгон нь асуудал дагуулж, маргаан үүсгэж, эс бөгөөд баталсан даруйдаа өөрчилдөг, хэлэлцүүлгийн шатанд унадаг “цадваргүй” парламент тун ховорхон байсан. Тэгвэл энэ удаагийн парламент олон шинэ түүхийг бичлээ. Гэхдээ дандаа муугаар. Хамгийн сонгодог жишээ нь 2017 оны төсвийн тодотгол хийх үед болсон процесс. Тодруулбал,

байлаа. Ингэснээр дотоодын банк санхүүгийн байгууллагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй гадны компаниудын мөнгө огтхон ч хамаарахгүй, ямар ч хяналтгүй шууд гадагшаа гарах нөхцөл бүрдэв. Энэ мэтээр УИХ гаргасан шийдвэрээ нэг ч онохгүй засах, баталсан хуулиа өөрчлөх асуудал нэг биш нэлээд хэд гарав. Х.Нямбаатар гишүүний оруулж ирсэн Эрүүгийн, Зөрчлийн хууль хаврын чуулганы үеэр хамгийн их шүүмжлэл сонссон хууль болсон. Өөрийнх нь намын туршлагатай гишүүд хүртэл түүхийг, тооцоо судалгаагүй хууль болсон хэмээн шүүмжилж, учраа мэдэхгүй бацаан чухал хуулиудыг самарч гүйцлээ гэх шүүмжлэл ч хэвлэлээр хүчтэй яригдаж байлаа. Эдгээр хуулиудыг боловсруулахдаа өмнөх алдааг нь засахгүй оруулж ирсэн нь хар тамхины хэрэгтэнийг өршөөх, эх орноосоо урвах заалтыг байхгүй болгосон зэргээс харагдаж байв. Энэ асуудлыг сөхөж тавьсан О.Баасагхүү гишүүнийг МАН-ын бүлгийн гишүүд цаашлаад Зам тээврийн дэд сайд нь хүртэл доромжилж байсан ч эцэстээ үнэнд гүйцэгдэж, өдгөө өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг УИХ-д өргөн бариад явж байх жишээтэй. Мөн Эрүүл мэндийн сайд А.Цогцэгэгийн нярай хүүхдийг хөхний сүүтгээр хооллох, хооллохгүй эсэхийг хуульчилсан асуудал ч олон нийтийн хүчтэй шүүмжлэлтэй тулгарсан. Валютын сангийн ах нарын хүсэл хэмээн шавдуулсаар батлуулсан приус машины татварыг 50 хувь болгох асуудлаа УИХ мөн л хэдхэн ч хөвөнгүй эргэж ярьсан.

Валютын санд “барьцаалагдаж”, Үндсэн хуулийг өөрчлөхөөр санаархав

Өнгөрөгч хаврын чуулганы үндсэн хоёр гол сэдэв Үндсэн хууль өөрчлөх болон Валютын сангийн хөтөлбөрт хамрагдах явдал. Тодруулбал, Олонуслын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдаж 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн багцад хамрагдахын тулд 2017 оны Төсвийн тодотголд өөрчлөлт оруулах асуудлыг хаврын чуулганы эхэнд хэлэлцүүлжээ. УИХ-ын даргын хэлсэнчлэн, төсвөө хяналттай, хэмнэлттэй болгох үүднээс иргэдийн хадгаламжийн хүүнээс татвар авах, долоон төрлийн татвар нэмэх, тэтгэврийн нас нэмэх, иргэдийн гол унаа болсон приус машины татварыг 100 хувь чөлөөлж байсныг 50 хувь болгох, бусад машиныг хөдөлгүүрийнх нь багтаамжаас хамаарч татвар ногдуулах зэрэг дандаа мөнгө босгох, ард түмний халаасыг тэмтрэх шийдвэрийг УИХ-д Сангийн сайд Б.Чойжилсүрэн оруулж ирсэн юм. Энэ асуудлаар УИХ удтал маргалдсан. Хүний өөрийн гишүүдийн эсэргүүцэлтэй тулгарч, ядарсан иргэдээ татвараар дарамталж буй нь зөв шийдвэр биш хэмээн маргаан мэтгэлцээн өрнөлөө. Гэвч МАН-ынхан “улс орны амьдрал хэцүүдлээ. Үүнээс өөр гарц байхгүй. Валютын сангийн хүсэл энэ байсан” хэмээсээр татвар нэмсэн тодотголыг батлуулж, улмаар тавдугаар сарын 25-нд ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдахаар болсон билээ. Ингэснээр Монгол Улс Валютын сангаас гадна Энэтхэг, Хятад, Япон зэрэг улс орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын зээл авах нөхцөл бүрдэв. Хаврын чуулганы хоёрдугаар анхаарал татах сэдэв нь Үндсэн хуулийн өөрчлөлт байв. Нэг нам дангаар ноёлсон энэ парламент анхнаасаа л бүх асуудлыг хүч түрэн шийдэж эхэлсэн. Тэр зангаа ч хаврын чуулганы үед харуулав. Үндсэн хуулийг өөрчлөх эсэх асуудлаар ажлын хэсэг гаргаж, иргэдийн дунд Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулсан. Үндэсний статистикийн байгууллагын санамсаргүй аргаар

ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

Монголын жүдогийн тамирчдыг гутаан доромжилсонг харамсч байна гэв

Монголын жүдо бөхийн холбооноос өнгөрсөн баасан гарагт Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан “Монгол ньюс” мэдээллийн төвд хэвлэлийн бага хурал хийлээ. Хэвлэлийн хуралд Азийн жүдо бөхийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Сахилгын хорооны дарга Б.Павва, Монголын жүдо бөхийн холбооны Ерөнхий нарийнбичгийн дарга, Олимпын шүүгч М.Бөхбат, олимпын

хүрэл медальт Д.Даваадалай, дасгалжуулагч Д.Баттулга нар оролцлоо. МАН-ын удирдлагуудын албан тушаалын наймааны тухай хуйвалдааны бичлэгийг олон нийтэд ил болгосон гэрч, иргэн Г.Доржзодовтой холбогдуулан 2017 оны зургадугаар сарын 15-ны өдөр хийсэн хэвлэлийн бага хурлын үеэр МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалангийн мэдэгд-

лийг үгүйсгэж, Монголын жүдогийн тамирчдыг гутаан доромжилсонд харамсаж буйгаа илэрхийлсэн билээ. Тодруулбал, Д.Амарбаясгалан “Хэн нэгэн жүдогийн тамирчин оноод Доржзодовыг цохнод унагаагчид гаж бодвол энийг М.Энхболд хүн явуулж цохиж унагаагчид гаж бодвол энийг бэлдчихсэн байгаа тул Ардын нам анхаарал тавьсан” хэмээн олон нийтэд мэдэгдсэн юм.

Тэгвэл энэхүү мэдэгдэл нь улс төрийн зорилгоор жүдо бөхийн тамирчдыг хүн зоддог, танхай, баймад үйл ажиллагаа явуулдаг гэж гүтгэн доромжилсон үйлдэл болсон хэмээн жүдогчид үзжээ. Тиймээс хэвлэлийн бага хурлын дараа МАН-д мэдэгдэл өгөхөөр болсон юм. Тэд хэвлэлийн хурлын дараа МАН-д мэдэгдлээ өгөхөөр болсон юм. Мэдэгдэлдээ Ерөнхийлөгчийн сонгуульд дуусахаас өмнө Жүдо бөхийн

холбоо, жүдогийн тамирчдаас уучлал гуйж, залруулга хийхийг МАН-ын удирдлагаас шаарджээ. Хэрэв энэхүү шаардлагыг хангахгүй бол жүдо бөхийн тамирчдынхаа гутаагдан доромжлогдсон нэр төрийг хамгаалж, шүүхэд хандаж нэр төрөө сэргээлгэх тухайгаа тус холбооныхон мэдээлсэн юм. Мөн тэд Ерөнхийлөгчийн сонгуульд шаардгаар өрсөлдөхийг нэр дэвшигчдээ хүслээ.

хөдөөдөр хэрэгжүүлсэн шиг хэрэгжүүлж, байгаль орчноо хамгаалахгүй бол дэлхийд эртнийд тооцогдох дархан цаазат газар устаж үгүй болох вий дээ. Цэцэг гүний хог дийлдэхээ болсон талаар холбогдох эх сурвалжууд анхааруулах болсон шүү дээ. Магадгүй Богд ууланд гал түймэр гарч, хог их болсон нь хамгаалалт, хяналт сул байгаатай ч холбоотой байж мэдэх юм. Тиймээс Богд уулыг хамгаалах ажлыг огт маргаж болохгүй.

НИЙГЭМ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ҮҮЛДРИЙН ХОНИОР МАЛЫН ГЕНЕФОНДОО АРВИЖУУЛАХ НЬ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Төд удалгүй онгоцны баруун талын хаалга нээгдэж, модон сараалжин хайрцагтай шилмэл үүлдрийн хонинууд буух нь тэр. Энэ бол Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох албаныхан болон хэвлэлийн бидний хүлээж байсан өнөөх чухал “ачаа” байв.

Манай улсын мал сүргийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд тодорхой хувь нэмрээ оруулсаар ирсэн. Гэсэн хэдий ч, сүүлийн жилүүдэд бэлчээрийн даац хэтэрсний улмаас мал сүргийн тоо толгойд бус чанар, үр ашигт нь илүү анхаарлаа хандуулах шаардлага нэгэнт бий болсон юм. Тэгвэл үндсэндээ 1990 оноос хойш буюу сүүлийн 27 жилд орхигдсон гэж хэлж болохуйц малын чанар, үүлдэр угсааг сайжруулах бодитой алхмыг Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж эхэллээ.

Засгийн газраас “Мах, сүүний анхдугаар аян”-ыг аяныг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ аяны хүрээнд салбар яам 2017 оныг “Малын чанарыг сайжруулах жил” болгон зарласан байдаг. Энэ хүрээнд махны болон нарийн ноосны чиглэлийн, дэлхийн шилдэг үүлдрийн хонь импортод Монгол Улсын малын генефондыг арвижуулсан нь энэ байлаа. Тодруулбал, энэ удаад Франц улсаас суффолк, беричон душер, романов, меринос гэсэн дөрвөн шилмэл үүлдрийн 657 хонийг агаарын хөлгөөр тээвэрлэн авчирчээ. Дэлхийн шилдэг үүлдрийн хонь хүлээн авах ажиллагаанд ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, тус яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л. Чой-Иш, Мал эмнэлэг үржилтний газрын дарга П.Ганхуяг, малын эмч, зоотехникч, мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч, бусад албаны хүмүүс оролцсон юм.

Махны, түргэн өсөлттэй хонь болох суффолк, бэришон зэрэг хонь нь эдийн засгийн хувьд үр ашигтай, гадаад зах зээлд



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ажил хангагджээ. “Малын чанар сайжруулах” ажлын хүрээнд Монгол малынхаа чанарыг сайжруулах ажлыг ч зохион байгуулж, хуулиа шинэчлэн баталж, богийн хээлтүүлэгчийн чанарыг дээшлүүлэх зэрэг ажлыг хийж байгаа юм. Ингээд дэлхийн шилдэг үүлдрийн хонин сүргийг хүлээн авах үеэр зарим албаныхны байр суурийг сонирхсоноо хүргэе.

Л.Баяртулга: Эдгээр хонийг хурган үед мах болон ноосны чиглэлээр ашиглах боломжтой

/ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга/

“Засгийн газраас “Мах сүүний анхдугаар аян”-ыг зарласан. Энэ хүрээнд ХХААХҮЯ-наас 2017 оныг малын үүлдэр угсаа, чанарыг сайжруулах жил болгон зарласан байгаа. Энэ хүрээнд Франц улсаас эхний ээлжинд дөрвөн үүлдрийн хонийг импортлож байна.

ч, махны чанарын үзүүлэлт доогуур байна. Иймээс төрөлжсөн аж ахуй байгуулах, эрлийзжүүлэх маягаар мах, ноосны гарцыг нэмэгдүүлэхээр төлөвлөдөг байна.

Монгол Улсын хэмжээнд хамгийн тулгамдаж буй нэг асуудал нь бэлчээрийн даац байгаа. Харин бэлчээрийн даацыг тоо толгой биш, нэг малаас гарах мах, ноосны гарцаар нөхөх замаар хамгаалж чадна гэж үзэж байна.

Guy Gerard Merlande: Бид Монголын уур амьсгалд тэсвэртэй дөрвөн үүлдрийг сонгосон

/“GE.O.DE”-ын Үржил селекц хариуцсан ТУЗ-ийн дарга/

“Бид өнөөдөр анх удаагаа Монголд махны чиглэлийн дөрвөн үүлдрийн хонь авчирч буйдаа туйлын баяртай байна. Манайх Франц даяарх 250 аж ахуй хоршоологчдын нийлүүлсэн бог малын 12

уур амьсгалд хамгийн тэсвэртэй байх дөрвөн үүлдрийг сонгож авчирсан. Эдгээр үүлдэр нь бэлчээрлэх бололцоотой. Нутгийн үүлдэртэй зохицох учраас эрлийзжүүлэхэд нутгийн малын махны үйлдвэрлэлийн үр өгөөж, ашиг шим нь нэмэгдэнэ. Бас ОХУ-ын эрс тэс уур амьсгалтэй Сибириэс гаралтай нэг үүлдрийг авчирлаа. Францад олон жилийн турш нутагшуулж, цэвэр үүлдэр нь хадгалж ирсэн. Монголын уур амьсгалд бүрэн зохицоно.

Г.Элдэв–Очир: 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэмд байлгана

/Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Мал эмнэлгийн улсын ахлах байцаагч/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Францын мал эмнэлгийн хорио цээрийн байгууллагатай Мал эмнэлгийн гэрчилгээг тохиролцсон. Үүнд, хонины халдварт

өвчний байдлыг Францыг тал баталгаажуулах талаар тусгасан байгаа. Хоёрдугаарт, Монгол Улсын импортод тавигдах халдварт өвчний шинжилгээг заавал хийлгэсэн байх гэсэн шаардлага тавьсан. Бид урьдчилсан бичиг баримтын шалгалтыг хийлээ. Монгол Улсын тавьсан шаардлагын дагуу шинжилгээ гэх мэт бүх зүйл нь хийгдсэн байна. Сая онгоцонд Буянт-Ухаа боомт дахь мэргэжлийн хяналтын албаны мал эмнэлгийн хяналтын байцаагчид бүгдийг нь хүлээн авлаа. Одоо Сонгинохайрхан дүүргийн мал эмнэлгийн албанд хүлээлгэж өгнө. Түүнд, Сонгинохайрхан дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагчид хяналт тавина. Ерөнхийдөө 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэмд байлгана. Энэ хугацаанд хонины халдварт өвчний шинжилгээг бүрэн гүйцэт хийж, лабораторийн шинжилгээгээр элдэв халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй тохиолдолд ашиглах боломж бүрдэх юм.


...Бид өнөөдөр анх удаагаа Монголд махны чиглэлийн дөрвөн үүлдрийн хонь авчирч буйдаа туйлын баяртай байна. Манайх Франц даяарх 250 аж ахуй хоршоологчдын нийлүүлсэн бог малын 12 үүлдрийн үржил, селекцийг хариуцдаг...

Б.Мөнгөн: Зургаан сартай суффолк үүлдрийн хонь 65 кг хүрдэг

/Дархан-Уул аймгийн малчин/

“Баруун Европын Францаас өндөр ашиг шимтэй дөрвөн үүлдрийн хонийг оруулж ирлээ. Зарим нь ноосных, зарим нь махны чиглэлийн хонь юм байна. Махны чиглэлийн хонь богино хугацаанд ашиг шимээ өгөх боломжтой. Суффолк үүлдрийн хуц 120-130 кг хүрдэг. Эм хонь бол 70-90 кг хүрдэг юм. Зургаан сартай хурга нь л 65 кг хүрдэг. Тэгэхээр жилдээ л ашгийг нь хүртэх бүрэн боломжтой.

Монгол хонь төлөг, шүдтэн хурч байж, 65 кг хүрдэг. Харин Суффолк үүлдрийн хурга зургаан сартайдаа өднй кг-д хүрнэ гэдэг нэлээд өндөр ашиг шимтэй юм. Тэгэхээр зөв арчилж, тордож чадвал жилдээ л ашгийг нь хүртээд байх боломжтой. Манайд нутагшуулах нь өөрөө нарийн ажиллагаа шаардана. Мал ямар нэгэн газар шууд нутагшуулах төвөгтэй байдаг юм. Миний бодлоор, тухайн улстай нь ижил төстэй уур амьсгал бүхий газар нутагт өсгөж үржүүлэх нь зүйтэй болов уу.



мах нийлүүлэхэд хэрэглэгчдэд танил болсон бүтээгдэхүүн аж. Сүүлийн жилүүдэд зарим малчид монгол хониндоо махны чиглэлийн дээрх үүлдрийн хуц тавьж хээлтүүлэн хавар төллөсөн хургаа бэлчээрээр нь маллаж, намар нь махны хэрэгцээнд борлуулж цаг хугацаа хэмнэж, ашгаа нэмэгдүүлсэн сайн туршлага ч байгаа юм.

Мөн ихэр төл өгдөг романов үүлдрийн хонь төллөх бүрдээ хоёр болон түүнээс олон төл гаргадаг аж. Эрчимжсэн хонины аж ахуй эрхлэгчид ихэрлэдэг романов эм хониндоо суффолк хуцыг тавьж, ихэр төл авч, тэднийгээ намар нь 60-аас дээш кг амьдын жинтэй болгон зах зээлд нийлүүлж, малаас авах ашгаа өсгөсөн жишээ олон байгаа.

Үүгээр зогсохгүй Говьсүмбэр аймагт өсгөж байсан Сүмбэр хонины чанарыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, тун удахгүй кракуль хонь импортод цөм сүрэгтэй болох бэлтгэл



Ихэрлэдэг Романов болон суффолк, беричон душер, романов, меринос зэрэг нарийн ноост хонинуудыг оруулж ирлээ. Эдгээр хонийг хурган үед мах болон ноосны чиглэлээр ашиглах боломжтой. Ялангуяа, хөнгөн үйлдэрт нарийн ноос шаардлагатай байгаа энэ үед хэрэгцээг хангахад ашиглагдана. Хэдий малын махаа гадаад улс оронд экспортлох талаар ярьж байгаа

үүлдрийн үржил, селекцийг хариуцдаг. Монголд зөвхөн малаа хүлээлгэн өгөх гэж ирсэнгүй. ХХААХҮЯ-нд тэдгээр мах, ноосны чиглэлийн хонийг хэрхэн яаж өсгөж, үржүүлэх, юуг анхаарах ёстой талаар сургалт зохион байгуулна.

Дээр нь худалдан авагч фермтэйгээ байнгын харилцаатай байж, сургалт, зөвлөгөө өгч ажиллах болно. Түүнчлэн, 12 селецкээсээ Монголын эрс тэс

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь Боловсролын салбарын мэдээллийн системийн багт JavaScript хөгжүүлэгч 2 хувь зөвлөхийг чадварын үнэлгээний аргаар шалгаруулж авна.

Сонирхсон этгээд хувь зөвлөхийн ажлын байранд тавигдах шаардлагыг <http://esis.edu.mn/hr/zar.pdf> линкээр татаж авна уу.

Дэлгэрэнгүй жагсаалтад орох этгээд битүүмжилсэн материалаа 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 17.30-аас өмнө Улаанбаатар хот, бага тойруу 44, Засгийн газрын III байр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 108 тоот өрөөнд ирүүлэн үү.

Бүрдүүлэх материалын жагсаалт:

- Танилцуулга (Хувь хүний, хийсэн бүтээлийн)
- Дэлгэрэнгүй анкет
- Дипломын хуульбар
- Холбогдох сертификат
- Одоо ажиллаж байгаа эсвэл өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

О.Дүнжиннамдаг
Харилцах утас: 51-263727
Мэйл хаяг: dunjinnamdag@mecs.gov.mn

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ - 2017

БУЛГАНЧУУД НЭР ДЭВШИГЧ Х.БАТТУЛГЫГ 100 ХУВЬ ДЭМЖИЖ, АНХДАГЧ БАЙХАА ИЛЭРХИЙЛЭВ

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулга эх орноо нар зөв тойрон, иргэд сонгогчидтойгоо уулзаж байгаа билээ. Тэрбээр энэ сарын 17-нд анхдагчдын өлгий нутаг, Халхын Цогт хунтайж, Чин Ван Хандорж, Хатанбаатар Магсаржавтэргүүтэйхорогчдын унасан газар болох Булган аймгийн иргэд, сонгогчидтой уулзлаа. Энэхүү уулзалтад нэр дэвшигчээс гадна Булган аймгийн АН-ын дарга Б.Ариун-Эрдэнэ, АН-ын дарга, УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн асан



Ц.Оюунгэрэл, Олимпын анхны аварга Н.Түвшинбаяр тэргүүтэй хүмүүс оролцсон юм. Уулзалтыг Булган аймгийн АН-ын дарга Б.Ариун-Эрдэнэ нээж, УИХ-ын гишүүн, АН-ын дарга С.Эрдэнэ тус нутгийн сонгогч олонд хандаж хэлсэн үгэндээ “Хүүхдийн мөнгө хасдаг, ахмадын хамтын тэтгэврийн хуулийг цуцалдаг ээлтэй төр байдаг юм уу” хэмээн сануулсан. Түүний дараа Булган нутгийн унаган хүү, Олимпын анхны алтан медалийг эх орондоо авчирсан Н.Түвшинбаяр аварга үг хэлсэн. Тэрбээр “Миний авсан алтан медаль анхных байгаад зогсохгүй Монголд маш их зүйлийг авчирч, өвлэрэл нягтралыг бий болгосон гэдгийг би жил ирэх тусам ухаардаг юм. Энэ бол зүгээр нэг медаль байсан биш Монголын заяаг түшсэн алтан медаль байсан юм шүү. Додугаар сарын 1-ний хар үйл явдлын дараа бий болж болох хар муу бүхнийг арилгасан гэдгээрээ ач холбогдолтой байсан юм” хэмээн хэлж, Ардчилсан намаас нэр дэвшигчийг дэмжихийг уриаллаа. Уулзалтын төгсгөлд Булган нутгийн ард иргэд нэр дэвшигчээс асуулт асууж, дэмжиж үг хэлж, урам хайрласан юм. Төмөр зам, оффшор данс гэх мэт өрсөлдөгч нараас явуулж буй хар пи артай холбоотой мэдээлүүдийг тэд тодруулж асуусан. Тэр дундаас ахмад сэтгүүлч Н.Рэнцэндорж нэр дэвшигч Х.Баттулгыг оффшор данстай хэмээн худлаа гүтгэж байгаад бухимдаж байгаагаа илэрхийллээ.

байтугай” хэмээв. Асуулт асууж, үг хэлсний дараа нэр дэвшигч Х.Баттулга “Ихэнх нь дэмжсэн үг хэллээ. Харин оффшортой холбоотой асуудлаар нэг хүн байр сууриа илэрхийллээ. Тэрбум ам.доллартай хүн байдаггүй юм байна, Монголд гэж. Яг шударга хөдөлмөрөөрөө ажиллаж, амьдрал байгаа хүмүүст тийм их мөнгө байхгүй ээ. Харин байгалийн байлгийг хувьдаа ашиглаж байгаа хүмүүст нууцхсан их мөнгө, тэрбум ам.доллар байгаа шүү. Ганхуяг гэдэг залуугийн ах нарыг оффшортойг нь илрүүлээд хэлчихээр буцааж дайрч байгаа юм” хэмээн хариуллаа. Уулзалтын дараа Булган нутгийн иргэд түүнийг эх оронч, ард түмнээ бодсон Ерөнхийлөгч болохыг хүсэн ерөөсөн юм. Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулга Булган аймгийн иргэдтэй уулзсаны дараа Дархан, Эрдэнэт хотыг зорилоо.

Х.Баттулга: Эрдэнэтийн 49 хувиас энэ үйлдвэрийг авч яваа 6000 гаруй ажилчин, уурхайчин хувьцаа эзэмших эрхтэй

Нэр дэвшигч Халтмаагийн Баттулга Эрдэнэт хотын иргэд, сонгогчидтой уулзлаа. Уулзалтад нэр дэвшигч Х.Баттулга, УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл, Орхон аймгийн Ардчилсан намын Ц.Баттөр тэргүүтэй албаны хүмүүс оролцож, ард иргэдийн сонирхсон асуултад хариу өглөө. Нэр дэвшигч Х.Баттулга уулзалтын үеэр хэлсэн үгэндээ “Монгол орны гэрэл гэгээтэй юм бүхэн Эрдэнэт үйлдвэртэй ямар нэг сэжмээр холбогддог. Улс орны эдийн засаг уналтад орж, төсөв санхүү улайх үед Эрдэнэт үйлдвэр л цус сэлбэж, гал алдах аюулаас аварч гардаг. Ийм хөдөлмөрч, бүтээгч ард түмэнтэй уулзан учирч байгаадаа баярттай байна. Манай баг сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн даруй Хэнтий аймгаас эхлэн эх орноо бүтэн тойрч, өдгөө 18 дахь аймгаатаа ажиллаж байна.

Юуны өмнө өнөөдөр үүсээд буй үл ойлгогдох гүжир гүтгэлэг мэдээллүүд хийгээд Эрдэнэт үйлдвэрийн хувьчлалын тухай байр сууриа хэлэх нь зөв болов уу. Сонгууль бүрийн өмнө элдэв гүтгэлэг, хар мэдээ хөвөрдөг. УИХ-ын сонгуулийн тухайд 500 гаруй хүн өрсөлддөг учир элдэв гүтгэлэг, хар мэдээ мэдээллүүд нөхт хүн рүү бус хэсэг булэг рүү, нам эвсэл рүү хандах нь

бий. Харин, Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр, гурван хүн л өрсөлддөг. Тиймдээ ч аливаа гүжир гүтгэлэг мэдээллийн аль нь үнэн, аль нь худал болохыг ялгаж салгахад бэрх байдаг. Сая уулзалт хийхээр орж ирэхэд “Баттулга Эрдэнэтийн 49 хувийг Элбэгдоржтой хувааж идсэн” гэх лоозон барьсан оюутнууд эгнэн зогсчээ. Сүүлийн үед миний бие өөрөө ч мэдэхгүй элдэв хөрөнгө мөнгө энд тэндээ гарч ирэх боллоо. Эрдэнэтийн хувааж идсэн гэх гүтгэлэг мөнөөх,лучиртугайг худал мэдээлэл, гүтгэлүүдийн нэг. Би хэзээ ч, хэнтэй ч нийлж худалтай хийж байсангүй, тийм зүйл ч болохгүй. Тэр дундаа улстөрчтэй нийлж нийм юм хийсэн хэмээн гүтгэж, бүхэл бүтэн нэвтрүүлэг хүртэл хийж байгаа нь харахад инээдтэй байна, тэр хүмүүс айж байна. Эрдэнэтийн тухай ярихын тулд эхлээд гурван зүйлийг тодотгох хэрэг гарах нь. Нэгдүгээрт, миний бие 2007 онд МоАХ-ны партизануудтайгаа Сүхбаатарын талбайд суулт хийж, Тавантолгойн орд газрыг Монгол, Хятадын хамтарсан “MCS” гэх компанид өгчхосөн байсны 96 хувийг буцааж авсан. Үүнийгээ би улс төрийн нэлээд том тэмцэл гэж ойлгодог. Энэ үйл явдлаас хойш Монгол Улсын Засгийн газраас иргэн бүрт 1072 хувьцаа олгосон нь 6.5 тэрбум тул нөөцтэй эл байлгийг Монгол Улсын Засгийн газар, Монголын ард түмэн буцаан авсан. Ингэснээр иргэн бүр хувьцаа эзэмшигч болж байсны та бүхэн санаж байгаа байх.

Хоёрдугаарт, Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Цонжинболдог дахь Чингис хааны морьт хөшөөг зүгээр нэг хүний нүд хужирлах гэж байгуулаагүй ээ. Эл хөшөөт цогцолборыг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор ашиглалтад оруулж, тэр жил төрсөн 10 мянган хүүхдэд үнэгүй хувьцаа олгож, “Женко тур бюро” ХХК-ийн хувьцаа эзэмшигч болгосон. Одоо энэ хүүхдүүд 10 настай болчихсон байна. Ирээдүйд сургууль соёлд ороод эл компаниасаа ногдол ашиг хүртэж, сурч боловсроход зориулах эзэмшигч байсан хүмүүс одоо ч хэвээрээ байгаа. Хувьцаат компанийн тухайд би хамгийн зөв шийдэл гэж харж, бодож явдаг. Тиймээс Эрдэнэтийн 49 хувиас Эрдэнэт үйлдвэрийг авч яваа 6000 гаруй ажилтан, уурхайчин хувь хүртэх эрхтэй, хувыдаа эзэмших ёстой гэж бодож явдаг. Нэг, хоёр,

гурва гэж оршил яриад байгаа нь өөрийнхөө өдий хүртэлх бизнесийн салбарын замнал, байр суурийг илэрхийлсэн хэрэг. Хувьцаат компанийн онолыг би хувьдаа зөв шийдэл гэж бодож явдаг 49 хувийн тухай асуудал дээр илэрхийлж байна” гэсэн юм. Уулзалт, ярилцлагын үеэр үг хэлсэн хүмүүсийн ярианаас онцлолоо.

С.Эрдэнэ: Эрдэнэт үйлдвэрийн 51 хувийг дахин нягтлах шаардлагатай

/УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга/

“Эрдэс баялгийн өлгий нутаг Эрдэнэт хотод саатаж, ажилчид, уурхайчид та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна. Саяманай нэр дэвшигч Баттулга маань хэлж байна, ажилчид, уурхайчид маань Эрдэнэтийн 49 хувиас хувь хүртэх эрхтэй гэж. Би санал нэг байна. Түүнчлэн, 51 хувийн асуудлыг ч дахин нягтлах, шалгаж үзэх шаардлагатай гэж үзэж байна. Эрдэнэт үйлдвэр Монголын ард түмнийг, Монгол Улсыг 40-өөд жил тэжээн тэтгэсэн. Цаашдаа өдий дайны хугацаанд үйл ажиллагаа явуулах боломжтой. Тиймээс 51 хувийг дахин нягтлах, шалгах шаардлагатай.

Э.Ариун-Эрдэнэ: Монгол Улсын ирээдүйн хөгжил цэцэглэлтийг дотроо зурж яваа гэдэгт итгэлтэй байна

/Соёлын тэргүүний ажилтан, “Outlaw” халтлагийн дуучин/

“Нэр дэвшигч Баттулга ах маань спорт, улс төр, бизнесийн салбарт өөрийн өнгө төрхийг бий болгож чадсан лидер хүн. Аль ч улс оронд, ямар ч цаг үед хөгжил дэвшилд хөтөлөгч лидерүүд нь зөвхөн улстөрч бус хар бор амьдрал үзэж туулсан, хөлс хүчээ урсгаж сайн сайхан амьдралд хүрсэн, олон талын нийгмийн идэвх, оролцоотой жинхэнэ удирдагч байдаг. Баттулга ах маань улстөрч, тамирчин мөн зураач, урлагийн хүн. Урлагийн хүмүүс аливаа юмыг төр өндгөөс харж чаддаг давуу талтай байдаг. Урлаг, спортоор хүмүүжж улс төрд хүн чанараа гэгээтэйг хүн аливаа юмыг олон талаас нь харж, зураглаж явдаг нь дамжиггүй. Баттулга ах Монгол Улсын ирээдүйн хөгжил цэцэглэлтийг дотроо харж, зурж яваа гэдэг итгэлтэй байна. Эрдэнэтчүүд эх оронч Ерөнхийлөгчөө дэмжинэ.



ЗАСАГТХАНЫХАН М.ЭНХБОЛДЫГ ДЭМЖИНЭ ГЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Ардын Намаас нэр дэвшигч М.Энхболд баруун таван аймагт ажиллаад хүлгийн жолоог нийслэлийн зүг заллаа. Алтай нутаг байгалийн үзэмж төгс бүрдсэн нутаг. Нэр дэвшигч алтайчуудтай “Монгол төр-Монгол гэр” мөрийн хөтөлбөрөө танилцууллаа. Алтайчууд хоёр мянган хүний багтаамжтай Спорт цогцолбортоо дөрвөн мянгуулаа цуглаж М.Энхболдыг угтан авсан юм. Түүнийг Ерөнхийлөгч асан Н.Багабанди, УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж, энэ нутгийнхны итгэлтэй хүлээж, төрд төлөөлөн суугаа УИХ-ын гишүүд дэмжин, хамт яваа билээ.

Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболдтой 20 гаруй жил хамтдаа ажиллаж буй, журмын нөхөр, ажлын сайн хамтрагч Ц.Нямдорж баруун таван аймагт хамт явах энэхэн зуур их баярлахын зэрэгцээ сэтгэлийн хөнгөн гуниг тээж яваа гэнэ. Баярлахын учир юу гэвэл, тэртээх 1997 онд Н.Багабандийг Ерөнхийлөгчид нэр дэвшихэд Ц.Нямдорж, Н.Энхбаяр хоёр түүнийг дэмжин явж байсан бол өнөөдөр М.Энхболдыг дэмжиж Н.Багабандитай хамт яваа нь. Харин 2005 онд Н.Энхбаярыг дэмжиж хамт явж байж. Хэрэв өдийд Н.Энхбаяр хүнээрээ байсан бол энэ цаг үед бид гурав хамтдаа М.Энхболдыгоо дэмжээд явах байсандаа хэмээн бодож хөнгөн гуниг тээлээ гэсэн.

Алтайчуудтай уулзах энэ үеэр УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж хоржоонтой ч үнэнийг илэрхийлсэн нэгэн зүйрлэл хэллээ. Монголын ард түмний сэтгэл зүрхэнд хоногшсон Ч.Лодойдамба гуайн зохиосон “Тунгалаг тамир” романы гол дүрүүдтэй Ерөнхийлөгчид нэр дэвшигчид төстэй санагдсан гэнэ. Тухайлбал, М.Энхболд төр засгийн ажлыг түрүүнд тавьж, хийж бүтээхийн төлөө өдөр шөнөгүй гүйдэг Засагтханы хөх харчуудын нэг Эрдэнэтийг төстэй бол Х.Баттулга ташуур атгачихсан, эвгүйхэн харж яваа нь тахар Бадарчтай, С.Ганбаатар Ардын жүжигчин Чимэд-Осор гуайн тоглосон эсэргүүний үед хувилгаан лам болдог дүртэй их төстэй хэмээсэнд алтайчууд нэгэн зэрэг алга ташсан нь олон хүнд нэгийг бодуулсан биз ээ.

УИХ-ын даргаар ажиллаж байхдаа Залуусын хөгжлийг дэмжих тухай хууль, Ахмадуудад насны хионг хүртээх Ахмад настны тухай хууль, Нялх балчир хүүхдийн хоол хүнсний тухай хууль, Батлан хамгаалах салбарын багц хууль, малчид, мал аж ахуйн салбарыг дэмжсэн томоохон хэд хэдэн хуулийг баталж, салбарынх нь эрх зүйн орчинг боловсронгуй болгоод амжсан. Одоогоор батлахаар хүлээгдэж буй хэд хэдэн хууль байгаагаас Биений тамир, спортын хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг салбарынх нь хоног тоолон хүлээж суугаа уулзалтад оролдогчид онцолж байлаа. Уулзалтад алтайчуудын бахархал болсон Чандмань сумын уугуул, “Хантайшир” дэвжээний бөх, Монгол Улсын гарьд Н.Ганбаатар оролцож, М.Энхболдыг дэмжихийг нутгийн зон олондоо уриаллаа. МАН өнгөрсөн оны сонгуулиар ялалт байгуулж, төр засгийг удирдсанаар дээрх байдал ард хорорч, малчдын амьдрал гэрэл гийсэн гэлээ. Ингэж Монгол Улсын нийгэм, эдийн засаг сэргэж, иргэдийн амьдрал өндийж байгаа энэ цаг үед өнөөдрөөс илүү маргаашийн төлөө Засагтханынхон сонгуульдаа идэвхтэй оролдож, М.Энхболдыг сонгохоо мэдэгдэж, хаалгаар хөөгдөөд гарсан хүмүүсийг тооноор оруулдаг монгол ёс байдаггүйг санууллаа.

С.ГАНБААТАР: БИ АРД ТҮМЭНДЭЭ ТАЙЛАНГАА ТАВЬДАГ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА



МАХН-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатар энэ сарын 18-нд ард түмэнтэйгээ хариуцлагын гэрээ байгуулж гарын үсэг зурлаа. Чин Ван Ханддоржийн өргөөнд болсон нээлтийн ёслолд нийслэлийн есөн дүүргийн иргэдийн төлөөлөл оролцож гэрээнд гарын үсэг зурсныг Монголын нотариатчдын төлөөлөл гэрчилж баталгаажуулав. Төрийн тэргүүн гурван сая ард түмнээ төлөөлөх үүрэг, хариуцлагыг ийнхүү өөрийн бие дээр андгайлан авч, гарын үсгээ зуран гэрээ байгуулж байгаа нь Сайнхүүгийн Ганбаатарын зүгээс Монголын улс төрд, нэр дэвшигчдэд, Ерөнхийлөгч нарт бий болгож буй шинэ дэвшил, шинэ жиншиг юм. “Монголын за андгай буй за” хэмээн монголчууд андгай тангарагт ач холбогдол өгдөг.

Сайнхүүгийн Ганбаатар ам, ажлын нэгдлийг хангаж ажилладаг Ерөнхийлөгч байна гэдгээ мөн үүгээр илэрхийллээ. Түүний ард түмэнтэй байгуулсан есөн зүйл бүхий гэрээний үндсэн агуулга “Ерөнхийлөгч болсны дараа ард түмэнтэйгээ байгуулсан гэрээгээ жил бүр тайлагнаана. Төрийн тэргүүн болсныхоо дараа өөрийн ах, дүү, хамаатан садангийн хэнд ч давуу эрх олгохгүй. Гэрээнд тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэхэд дөрвөн жил хангалттай. Иймд миний бие Ерөнхийлөгчөөр зөвхөн дөрвөн жил ажиллана” гэсэн байна. Мөн үүнийгээ эх орон даяар зарлан тунхаглаж байгаа бөгөөд гэрээг 21 аймаг, сум, баг, хороонд шуурхайлан хүргэх ажлыг наран мандаа зүүн бус нутгаас буюу Их Эзэн Чингис хааны мандлсын газар Хэнтий аймгаас эхлүүлэх юм.

ДЭЛХИЙ

Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Асуултын тухайд иргэд Аюулгүй байдлын долоо хоногоос эхлэн өгч эхэлжээ. ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгчийн мэдэгдсэнээр иргэд ихэвчлэн нийгмийн халамж, улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой сэдвээр асуултаа ирүүлсэн аж. Харин эдийн засаг болоод хямралыг гэтлэх талаарх асуултад хариулахдаа хамгийн сүүлийн үеийн тоон мэдээллүүдийг танилцуулсан байна. Тодруулбал, Оросын ДНБ гурван улирал дараалан өсчээ. Энэ оны эхний дөрвөн сарын байдлаар, эдийн засгийн өсөлт 0.7 хувьтай гарсан байна. Үүний сацуу Төв банкны алт, валютын нөөц болон гадаадад байршуулсан нөөц нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ. Өнгөрсөн онд нөөцийн нийтийн хэмжээ 368 тэрбум ам.доллар байсан бол 2016 оны сүүлчээр 378 тэрбум ам.доллар, энэ онд 405 тэрбум ам.доллар болж өссөн гэдгийг төрийн тэргүүн дурьдлаа. Харин Оросын эсрэг авсан хориг арга хэмжээний талаарх асуултад тэрбээр “Орос орон хөл дээрээ зогсч эхэлсэн тэр цагаас хойш бид эдийн засгийн хоригийн нөхцөлд амьдарч байна. Крым ч юм уу эсвэл өөр асуудал байгаагүй тохиолдолд ч гэсэн Оросыг хазаарлан барихын тулд тэд ямар нэгэн өөр зүйлийг бодож олох л байсан” гэжээ.

Хориг арга хэмжээ Орос улсад нөлөөлсөн, гэхдээ ноцтойгоор нөлөөлөөгүй гэж В.Путин үзэж байна. Энэ хориг бол хоёр үзүүртэй илд бөгөөд хориг тавьсан талд ч мөн адил хохирол учруулсан гэдгийг тэрбээр дурьдлаа. Хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадварын тухайд үр тарианы экспорт, тэр дундаа улаан буудайн экспортоор ОХУ дэлхийд тэргүүлэх болсон гэдгийг В.Путин

дурьдаад, тус улс шувууны махны хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангадаг болсныг сайшаан тэмдэглэжээ. Түүнчлэн, тэр бүл олон нийтэд дэлгээд байдаггүй хувийн амьдрал, охидынхоо тухай ч ярьсан байна. Шууд ярилцлагын үеэр хоёр дахь зэв нь төрөөд удаагүй байгаа талаар ярьсан нь хэвлэл мэдээллийн анхаарлыг татсан юм. Түүний хувьд гэр бүлийнхээ дотоод асуудлыг тэр

...01.30 цагийн үед орон сууцанд гал гарч, дөрвөн цагийн дотор гал байшинг бүхэлд нь хамарсны улмаас хэдэн арван хүн, хүүхэд хэн нэгнээс тусламж эрсээр амьдаараа шатаж нас барсан харамсалтай хэрэг гарсан юм. Албаныхны хамгийн сүүлчийн мэдээллээр 30 хүн нас барсан нь тогтоогджээ. Гэхдээ энэ тоо цаашид өсч магадгүй байгаа юм. Учир нь 58 хүн ор сураггүй болсонд тооцогдож байна...

бүр нээлттэй яриад байдаггүй билээ. В.Путин хоёр охинтой. Том охин Мария нь 32 настай бол удаах нь 30 настай юм. Тэдний талаар ярихдаа ОХУ-ын төрийн тэргүүн “Тэдний талаар янз бүрийн л яриа гардаг. Охид минь ОХУ-д Москвадаа амьдарч байгаа” гэжээ. Мөн том зэв нь цэцэрлэгт орсон бол хоёр дахь зэв нь төрөөд удаагүй аж. Түүнчлэн, В.Путины охид улс төрөөс ангид судалгаа

шинжилгээ, боловсролын салбарт ажилладаг гэж ярьсан байна.

Лондонгийн 24 давхар барилгад гал гарч, 30 хүн нас барлаа

Их Британийн нийслэл Лондон хотын баруун этгээдэд байрлах 24 давхар өндөр барилгад энэ сарын 14-ний өдөр үнсэн товрого боллоо. 1974 онд ашиглалтад орсон “Грэнфилл таур” гэх хотхоны байранд 120 орх амьдардаг байжээ. Гэвч, мөн өдрийн 01.30 цагийн үед орон сууцанд гал гарч, дөрвөн цагийн дотор гал байшинг бүхэлд нь хамарсны улмаас хэдэн арван хүн, хүүхэд хэн нэгнээс тусламж эрсээр амьдаараа шатаж нас барсан харамсалтай хэрэг гарсан юм. Албаныхны хамгийн сүүлчийн мэдээллээр 30 хүн нас барсан нь тогтоогджээ. Гэхдээ энэ тоо цаашид өсч магадгүй байгаа юм. Учир нь 58 хүн ор сураггүй болсонд тооцогдож байна. Лондонгийн цагдаагийн газрын Стюарт Кунди “Бид энэ сарын 14-ний шөнө Грэнфилл Таурт байсан оршин суугчдын тоог гаргахаар ажиллаж байна. Тиймээс илүү тодорхой мэдээлэл өгөх боломжгүй. Тухайн үед байшинд байсан эсэх нь тодорхойгүй байгаа 58 хүний тухайд харамсалтай нь нас барсан байж болзошгүй” гэж нэмж хэлжээ.

Одоогоор нас барсанд тооцогдож буй 58 хүний 30 нь нас барсан гэдэг нь тодорхой болсон бөгөөд 16-ынх нь цогцос Цогцос хадгалах газарт иржээ. Түүнчлэн, байшинд амьд хүн байх ямар ч магадлал байхгүй гэдгийг цагдаагийнхан тодотгож байна. Осол гарсны дараа хатан хаан хоёрдугаар Элизабет эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй ард иргэдээ иргэсэн. Тухайн үед тус улсын иргэд Ерөнхий сайд Тереза Мэйг 80 гаруй настай хатан



Лондонгийн барилгад гал гарч, В.ПУТИН ИРГЭДТЭЙГЭЭ “ШУУД ЯРИЛЦСАН” ДОЛОО ХОНОГ



хаан иргэдээ эргэчихээд байхад, нэг ч удаа ослын газарт харагдаагүй хэмээн шүүмжилж байлаа. Тэгвэл ЕХ-ноос гарах хэлэлцээрийг эхлүүлэх том ажилтай ява тэрбээр эцэст нь шатсан байшинд очиж аврагчид ард иргэдтэйгээ уулзжээ. Мөн хохирогчдын ард гэрт тусламж олгохоо энэ үеэр мэдэгдсэн байна. 1974 онд баригдсан уг барилгад өнгөрсөн жил засвар хийн гадна талаас нь дулаалга хийсэн. Дулаалгын материал

нь галд амархан авалцдаг материал байсан байх гэсэн таамгийг галын шинжээчид хийгээд байна.

Гельмут Коль таалаа төгслөө

ХБНГУ-ын Засгийн газрыг 16 жилийн туршид /1982-1998он/ тэргүүлсэн “Германы эв нэгдлийн канцлер” Гельмут Коль 87 насандаа өөд болжээ. Ийм почирдом мэдээг анх “Bild” таблоид мэдээлсэн бол дараа нь уг мэдээллийг “Германы Христийн ардчилсан холбоо” баталжээ. Хоёр Германыг нэгтгэх үйл явцад голлох үүрэг гүйцэтгэсэн ХБНГУ-ын канцлер асан энэ сарын 16-ны 09:00 цагийн үед Рейнланд Пфальц холбооны мужийн Людвигсхафен-ам-Райн хотод гэртээ нас баржээ. Тэр мөчид түүний дэргэд эхнэр Майке Коль-Рихтер байсан байна. Гельмут Коль сүүлийн жилүүдэд олон нийтийн өмнө гарч ирэх нь туйлын ховор болсон нь эрүүл мэндтэй нь холбоотой байсан бөгөөд тэрээр ярилцлага ч өгөхөө больжээ. 2008 онд Г.Коль агсан толгойндоо гэмтэл авснаас хойш тэргэнцэр дээр суух болсон билээ. “Тарамгай төрийн зүтгэлтэн”, “Германы суут хүү” гэж Г.Кольийг бүх дэлхийн улстөрчид, олон нийтийн зүтгэлтнүүд үнэлж байгаа нь түүхийн хуудсанд багтай байр суурийг эзэлсэн улстөрч гэдгийг харуулж байгаа юм. Г.Коль 1930 оны дөрөвдүгээр сарын 3-нд Людвигсхафен хотод банкны ажилтны гэр бүлд төржээ. Тэрээр бага залуу наснаасаа эхлэн улс төрийг сонирхох болсон бөгөөд 16 насандаа Германы Христийн ардчилсан холбооны гишүүн болж, улмаар тус намын залуучуудын байгууллагыг үүсгэн байгуулагчдын нэг болжээ. 1959 онд тус намаас Рейнланд-Пфальцын газрын парламент /ландтаг/-ын депутатаар сонгожээ.

Үүнээс хойш түүний улс төрийн карьер эхэлсэн ба 1966 онд Г.Коль тус намын газрын байгууллагын дарга болсноор намынхаа холбооны удирдах зөвлөлийн гишүүн болжээ. Гурван жилийн дараа тэрээр Рейнланд-Пфальцын ерөнхий сайд болсон бол 1973 оны зургадугаар сард Германы Христийн ардчилсан холбооны даргаар сонгогдож түүний үнэлж баршгүй тэргүүн манлайлагч нь болсон юм. 1982 онд Социаль-либерал эвсэл задран унасны дараа аравдугаар сарын 1-нд түүнийг ХБНГУ-ын Засгийн газрын тэргүүнээр томилсон юм. Тэрээр канцлерын албан тушаалд 16 жил ажилласан нь урьд хожид байгаагүй удаан хугацаанд ажилласан төрийн тэргүүн болж байгаа юм. 1990 онд Дэлхийн II дайнд ялсан улс гэрээнд “хоёр дээр нэмэх нь дөрөв” томьёоллоор амжилттай хэлэлцээ хийсний дүнд хоёр Германыг нэгдэх бололцоог бүрдүүлжээ.

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Бүсийн оношлогоо эмчилгээний төвд дижитал рентген оношилгооны аппарат
Тендер шалгаруулалтын дугаар: ОР-156/2017

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Бүсийн оношлогоо эмчилгээний төвд дижитал рентген оношилгооны аппарат нийлүүлэх тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
Санхүүгийн тайлан: 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлэх

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн барааг нийлүүлсэн туршлагатай байх

Тусгай зөвшөөрөл: Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх

Тендерийн хамт 2,000,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гарган ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 07-р сарын 17-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 07-р сарын 17-ны 09 цаг 30 минутад цахимаар Орхон аймгийн ЗДТГ-ын Нэг цонхны үйлчилгээ, ОНӨГ-ын Сургалт мэдээллийн танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй. Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас: 70358570

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь “Орон сууцны байруудын зоорийн давхрын шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг төсөв боловсруулах” зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь: Налайх дүүргийн 2 дугаар хорооны 42-47 байруудын зоорийн давхрын шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг төсөв боловсруулах болно.

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

3. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 06-р сарын 29-ны өдрийн 15:00 цагийн дотор ирүүлнэ үү.

Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж,
Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын байр, Худалдан авах ажиллагааны алба, Утас 70232788

ЦАГ ҮЕ

УРАН БҮТЭЭЛЧ

“ЯПОН ЦЭРГИЙН ЦОГЦОЛБОР” ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН БОЛНО

Зохиолч, сэтгүүлч Гомбын БААТАРНУМ

Ерээд он хүртэл Дамбадаржагийн хийдийн баруун хойд энгэрт “Япон цэргийн булш” хэмээх том цагаан хашаа цайран харагддаг байлаа. Харин сүүлийн 20 гаруй жилд мөнөөх хашаа ор сураггүй болж, оронд нь томоохон бүтээн байгуулалтын цогцолбор боссоныг хэн хүнгүй мэдэх билээ. Халх голын байлдаанаас олзлогдсон япон цэргүүд хүнд хүчир хөдөлмөрт нухлагдаж байхдаа зарим нь өвчнөөр нас барж, энэ газарт оршуулагдаж байжээ. Хэдийгээр хүний нутагт өнгөлзөж, бүтэлгүйтсэн ч өрөвч сэтгэлтэй монголчууд тэдэнд тэгтлээ хүйтэн сэтгэлээр ханддаггүй байсныг хүмүүсийн яриа, ном, товхимолд бичиж үлдээснээс гадарлах болсон юм. Тэр ч байтугай, тухайн он жилүүдэд Хилийн цэргийн ахмад цолтой байсан бидний аав, баривчлагдсан япончуудтай ажиллаж байхдаа хүндээр өвчилж, “Айргийн сувилал” зэрэг газраар олон сараар эмчлүүлсэн боловч илааршилгүй байсаар цэргээс бэлтгэлээр халагдаж орон нутагтаа очсон гэдэг. Бидний ээж угийн өрөвч сэтгэлтэй, өглөгч нэгэн л дээ. Тэр үед япон цэргүүд Д.Сүхбаатарын талбайд ажиллаж байсан бололтой. Ээж маань тэднийг үнэнхүү сэтгэлийн угаас өрөвдөхдөө хайрцаг хайрцаар нь “Паширос” тамхи, бас ойр зуурын идэх юмыг цүнх, халаасандаа чихэж аваад л очдог, “Харуул манааных нь сиймхийг тааруулж байгаад хашаа давуулан шиддэг байсан даа” гэж ярьдагийг нь тод санаж байна. Ойрмогхоны нэгэн өдөр миний бие өөрийн багш, олноо “DZ Map” хэмээн алдаршсан, Улс төрийн тоймч Б.Дашзэвэгийн хамт япон цэргийн цогцолборыг сонирхохоороо чихдөө тэндэхийн Менежер Ч.Гантогтох гэдэг залуутай танилцаж, сэтгүүлч хүний сонууч зандаа хөтлөгдсөнөөгөө уншигч олонтойгоо хуваалцъяу.

Ийм онцгой газарт ажиллах хувь тэр бүр хүнд олохгүй дээ. Энд нутаг ус үл хамаарах ч, аль нутгийнх гэдгээс яриагаа эхлээ...
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын уугуул. 2002 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн долдугаар сургуулийн наймдугаар ангийг дүүргээд Техник технологийн коллежийн Цахилгаанчны ангид орж суралцсан. Сургуулиа 2006 онд төгсөөд “Нийслэл өргөө” компанид хэсэг хугацаанд ажилласан. Бас 2008 онд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид цэргийн албаа хаагаад асан гэж байгаа.
Өө, тэргэл жинхэнэ эр хүн юм байна. Харин ийм онцгой газар хэрхэн шалгуур давж



(Илэн далангүй хөөрөлдөөн)

ажиллах болов оо?

-2016 оны зургадугаар сард “Япон цэргийн цогцолбор хөшөөний менежер” гэдэг албанд ажилд орсон. Ажлын онцлог гэвэл өвөл, зунгүй байж, энэ орчиндоо хяналт тавина. Зундаа мод тарина, аялал жуулчлалаар болон ажил албаны шугамаар ирсэн япон хүмүүст цогцолбор хөшөөгөө тайлбарлан танилцуулдаг. Зөвхөн япон гэжгүй, сонирхохоор ирсэн хүн бүхэнд чөлөөтэй үйлчлэх ёстой. Уг нь манай хүргэн ах Б.Нэргүй гэдэг хүн энэ цогцолбор хөшөө баригдаагүй, бүр шарил байхад нь миний одоогийн ажлыг хийж байсан. Ах маань бурхан болсон учраас би ажлыг нь үргэлжлүүлж байгаа юм.

Цогцолбор хөшөөнд олон хүмүүсийн овог, нэр байгаа бололтой. Жаахан тайлбар хийгээч...
-Ах маань амьд сэрүүн байхдаа ярьж байсан юм. Уг нь Халх голын дайнаас олзлогдсон 98000 япон цэрэг Манжуурт байснаас 12000 цэрэг нь Сибирээр дамжин, 1945 оны хоёрдугаар сарын дундуур Алтанбулагийн хилээр Монголд орж ирсэн юм билээ. Тэр хол замыг дийлэнхдээ явганаар туулсан гэж бодохоор ямар хүнд нөхцөлд байсан нь ойлгомжтой. Тийм ч учраас цэргүүдийнх нь бараг 90 хувь уушигны ханиад, хатгаа, бусад төрлийн өвчтэй байжээ. Эмнэлгийн анхны тусламжийг Алтанбулагт үзүүлсэн гэсэн. Олзлогдсон цэргүүдийн хуаран Хужирбулан, Гачууртад төвлөрч байсан бололтой. Тэгээд бие бялдараар гайгүй хэсгийг нь хотод, арай нас ахимаг хүмүүсийг нь мэргэжлийн дагуу Налайх, Батсүмбэр зэрэг газарт уурхай, ногоо тариалах ажилд ашиглаж байжээ. Олзлогдсон япон цэргүүд Засгийн газрын ордон, Д.Сүхбаатарын талбай, Улсын төв номын сан, Дуурь

бүжгийн эрдмийн театр зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлыг хийж, манай улсын нүүр царайг өөрчлөхөд багагүй хувь нэмрээ оруулсныг хойч үе мартаж болохгүй юм даа. Дамбадаржаагийн хийдийн хашаанд “П” хэлбэрийн хоёр генералд зориулан, тусгайлан босгосон хөшөө байгаа нь тэр.
Цогцолбор хэзээ ашиглалтад орсон бэ?
-Бүтээн байгуулалтын ажил нь 2000 онд эхэлж, 2001 оны аравдугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Тэр цагаас янз бүрийн ажлаар Монголд ирсэн япон хүмүүсийн цуваа ер тасраагүй. Бүр зарим нь онгоцноосоо буугаад л шууд наашаа ирдэг гэсэн. Эндээс,

Нүүц биш бол энд хэчнээн хүний оршуулга байсан юм бол?

-Одоо нууцлаад байх юу байхав дээ. Энд нийтдээ 835 хүний оршуулга байсан гэсэн. Мөн Хужирбуланд 240, Батсүмбэрт 60 орчим, Алтанбулагт 195, Өгийнуурт таван хүний шарил байсныг 1999 онд бүгдийг гарган авч, 2000 онд Төв аймгийн Алтанбулаг суманд чандарлаж, нутаг руу нь авч явсан байна. Хамгийн олзуурхуштай нь тэр хүмүүсийн овог, нэр, хэдэн өвд ямар өвчнөөр хаана нас барсан зэргийг маш сайн бичиж үлдээсэн нь монголчуудын маань хүнлэг чанарын нэг илэрхийлэл, бас япончууд хүмүүсээ ямар ихээр хүндэтгэдгийн нэг тод жишээ болон үлджээ. Зөвхөн Монголд ч биш, орос, хятад зэрэг оронд цаг бусаар насан эцэслэсэн цэргүүдийнхээ шарилыг ч мөн нэгэн адил авсан гэсэн. Өнгөрсөн онд МУЗН-ээс 10, Японоос 20 хүний бүрэлдэхүүнтэй баг Халх голд малтлага хийж, 20 япон цэргийн шарилыг гарган авч чандарлан, мөн нутаг руугаа авч явсан.

Энэ цогцолборт хэмжээгээр бага ч онцгой

нэгэн хөшөө байх юм. Учир жанцанг нь мэдэх үү?

-Хамгийн дээд талд нь нэг том генералын оршуулга, доогуур нь цэргүүдийнх нь оршуулга байсан юм билээ. Япон цэргүүд тэр генералаа маш ихээр хүндэтгэдэг байсан гэсэн. Тэр генералд зориулан, тусгайлан босгосон хөшөө байгаа нь тэр.

Цогцолбор хэзээ ашиглалтад орсон бэ?

-Бүтээн байгуулалтын ажил нь 2000 онд эхэлж, 2001 оны аравдугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Тэр цагаас янз бүрийн ажлаар Монголд ирсэн япон хүмүүсийн цуваа ер тасраагүй. Бүр зарим нь онгоцноосоо буугаад л шууд наашаа ирдэг гэсэн. Эндээс,



ЭМЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

Яагаад ходоодны хорт хавдрын талаар мэдэх ёстой вэ?

Манай улсад хорт хавдартай гэж оношлогдсон нийт хүн амын 75 хувь нь буюу дөрвөн хүн тутмын гурав нь III, IV шатандаа жожуу оношлогддог. Тэр дунд ходоодны хорт хавдрын өвчлөл ...-т, нас баралт ...-д жагсаж байна.

Ходоодны хорт хавдрын 2.7 хувь нь I, 11 хувь нь II, 43 хувь нь III, 42.5 хувь нь IV үе шатандаа оношлогддог бөгөөд нийт өвчлөгсдийн 87.8 хувь нь нэг жил, 5.3 хувь нь 1-2 жил, гурван хувь нь 3-4 жил, 2.2 хувь нь тав хүртэлх жил, 1.7 хувь нь таваас дээш жил амьдардаг байна.

Иймээс л иргэд ходоодны хорт хавдрын талаар мэдлэгтэй болж, өөрсдийгөө болон гэр бүлийнхээ өвчлөлөөс урьдчилан сэргийлэх шаардлага нэгэнт тулгарчээ.

Ходоодны хорт хавдар гэж юу вэ?

Бид ходоодны хорт хавдрын талаарх мэдээллийг цувраар бэлтгэн хүргэв. Энэ удаад ходоодны хавдрын талаар ерөнхий ойлголтыг хүргэе. Ходоод нь хоол боловсруулах замын дээд хэсэг бөгөөд хоолыг нарийн гэдэс рүү дамжуулдаг. Ходоодны эрүүл эсүүд хяналтгүйгээр үржиж, хавдрыг бий болгодог.

Ходоодны хорт хавдрын хувьд хавдрын урьдал үеэс хавдар болж хөгжих хугацаа удаан байдаг боловч хавдрын урьдал өөрчлөлттэй байх үедээ шинж тэмдэг бүдэг байдаг тул тэр бүр оношлогддоггүй.

Ходоодны хорт хавдрын шалтгаан юу вэ?

Ходоодны хорт хавдарт хүргэж буй хүчин зүйл нь ходоодны хоргүй хавдар боловч хавдрын эс үүсэхэд нөлөөлөх олон өвчнүүд байдаг.

- Үүнд:**
Хеликобактерийн халдвар / ихэвчлэн ходоодны шархлаат өвчин болон архаг ходоодны үрэвслийг үүсгэдэг ба хамгийн гол эрсдэл болоод байна/
Хоол боловсруулах замын бусад хэсгийн хавдар
Ходоодны ургацаг /ходоодны эсээс гаралтай хэвийн бус ургацт, 10-20 хувь хавдарт шилждэг/
Лимфома /цусны хавдар/

Мөн дараах хүмүүс ходоодны хорт хавдраар илүүтэй өвчилж байна:

ээрэг 4000 гаруй мод суулгаад байна. Сардаа 750000 төгрөгийн цалинг хэн өгөх вэ дээ. Тийм учраас энэ газрыг сайхан цэцэрлэгт хүрээлэн болгох нь бидний гол зорилго болоод байна даа.

Сэтгүүлчийн зурвас:

Ч.Гантогтох бид хоёрын яриа ийнөөдрөгсэтгэлээр өндөрлөсөн юм. Ажил олдохгүй байгаа энэ цаг үед нэг нь ч гэсэн ажилтай, бас боломжийн цалинтай байна гэдэг сайхан хэрэг. Харин хүний итгэлийг дааж ажиллах нь л монголчуудын хувьд чухал гэдгийг хэлэхэд илүүдэхгүй болов уу. Гэхдээ Ч.Гантогтохыг сургууль, дамжаа дүүргэсэн, цэргийн алба хаачихсан, нэлээд догь нэгэн болохыг анзаарсан учраас энэ талд асуудалгүй нэгэн болохыг хэлэх байна. Ахных нь гэр бүл А.Сүглэгмаа гэдэг хижээл насны эмэгтэй энэ үеэр бидний ярианд оролцож, анх сахиул, менежерээр ирж бүхий л ажилд гар бие оролцсон, одоо ч ажилласаар байгаа тухайгаа өгүүлсэн. Түүний ярьснаар, зуны улиралд олон хүнтэй харьцах нь маш сайхан байдаг аж. Харин өвөл болохоор ирэх хүмүүсийн тоо цөөрч, жаахан уйтгартай байдаг гэнэ. Цаашдаа ч тогтвор суурьшилтай ажиллаж, маш сайхан цэцэрлэгт хүрээлэн байгуулах нь энэ насны буян гэж боддог юу ярьсан. Тэдний ажлыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хот тохижуулах газраас ч дэмжин гэгдээ илэрхийлжээ. Энэ бяцхан газар хэдийгээр “Япон цэргийн цогцолбор” нэртэй ч, цаашдаа нийслэлчүүдийн зорин очдог, нээлттэй томоохон цэцэрлэгт хүрээлэн байх бололтой.

-Танай цогцолборын цаашдын зорилго...?

-Япончууд цогцолбороо томоохон цэцэрлэгт хүрээлэн болгох төлөвлөгөө боловсруулсан юм билээ. Мэдээж, төр, засаг нь ч маш их дэмжиж байгаа байх. Өнөөдрийн байдлаар хайлаас, гацуур, үрэл, монос, чацаргана



- Ахимаг нас /50-с дээш настай/
Эрэгтэйчүүд (эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоёр дахин илүү өвчилдөг)
Тамхичинд (тамхи татах үед тамхины утаа ходоод руу орж түүнд агуулагдаж буй хорт бүтээгдэхүүнүүд ходоод салст бүрхүүлийг гэмтээдэг)
Гэр бүлийн хэн нэгэн нь ходоодны хорт хавдраар өвчилсөн
А (II) бүлгийн цустай
Таны амьдралын буруу хэв маяг ходоодны хорт хавдар үүсэхэд нөлөөлж болно.
Даршилсан, давсалсан, утсан бүтээгдэхүүний хэрэглээ
Гэнэт их идэх
Архины хэрэглээ
Хоолыг буруу хадгалах
Жимс, ногоо бага хэрэглэх

Шинж тэмдэг

Ходоодны хорт хавдар эрт үедээ шинж тэмдэг илэрдэггүй. Гэхдээ ходоодны үрэвсэл, шархлаат өвчний сэдэрл зэрэгтэй андуурагдаж болдог.

Эрт үед илрэх шинж тэмдгүүд:

- Бие сулрах
- Ядрах
- Хоолны дуршил буурах
- Ажлын чадвар буурах
- Турах
- Зовууриас шалтгаалж дуртай хоолоо ч идэх хүсэлгүй байх
- Хавдрын хэмжээ томрох, өвчин даамжрах тусам шинж тэмдгүүд илүү нэмэгддэг.

Үүнд:

- Дисфаги (улаан хоолой, ходоодны заг хэсэгт үүсгэвэр байрласан бол эхлээд хоол унд залгихад төвөгтэй байх ба цаашид шингэн зүйл залгихад ч хэцүү болно)
- Бөөлжилт (ходоодны доод хэсэг буюу 12 хуруу гэдэс, ходоодны хооронд байрласан хавдрын үед юм идээд удалгүй идсэн зүйлээрээ бөөлжих)
- Цээж байнга гашуу оргих (аюулхай орчим дахь өвдөлт нь нуруу руу ихэвчлэн дамжиж өвдөнө)
- Жин алдах
- Гэдэс томрох (хэвлийн хөндийд шингэн хуралдсанаас шалтгаална)
- Аюулхайд ямар нэг үүсгэвэр тэмтрэгдэж болно (хавдар хэвлийн хөндийн урд хана хүртэл түрж ургаснаас)

ЗАРЛАЛ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны даргын ажлын байранд материал хүлээн авч байна.

Тавигдах шаардлага:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер мэргэжлээр их, дээд сургууль төгссөн.
- Төрийн албанд таваас доошгүй жил ажилласан. Мөн удирдах албан тушаалд ажилласан туршлагатай байх.
- Гадаад хэлний зохих мэдлэгтэй
- Компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг сайн эзэмшсэн.
- Багаар ажиллах чадвартай.
- Ёс зүй, харилцааны соёл эзэмшсэн.

Ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж, ажилд орохыг хүссэн иргэн доорх материалыг бүрдүүлэн ЭМХТ-ийн 103 тоотод 2017 оны зургадугаар сарын 21-нд багтаан материалаа ирүүлнэ үү.

Холбоо барих утас: 88046810

STRESS

ФОТО СУРВАЛЖЛАГА

Дэлхийн йогийн өдрийг тэмдэглэлээ

Энэ сарын 21-ний өдрийг дэлхийн Йогийн өдөр болсон олон улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх болсон билээ. Энэхүү санаачлагыг Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модиг гаргаж 2015 онд НҮБ дэмжсэн бөгөөд манай улсад ч энэхүү өдрийг жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жилийн "Йогийн өдөр" ажлын өдөр тохиож байгаа тул йогоор хичээллэгчид, багш, сонирхогчид очигдөр Сүхбаатарын талбайд цугларч йогийн дасгал хийж, нэг өдрийг идэвхтэй өнгөрүүлсэн байна.

Түүнчлэн, Дэлхийн Йогийн өдрийг тохиолдуулан Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модиг илгээлт явуулжээ. Тэрбээр "Өнөөдөр йог нь бидний оюун ухаан, бие махбод, сэтгэлгээг нэгтгэж байна. Сайн сайханд хүрэх зам нь йогоор дамжин хэрэгжинэ. Тиймээс йогийг олон нийтийн хөдөлгөөн болгож хувиргахыг хүсч байгаа бөгөөд даян дэлхийн энхтайван, эв зохицол, аз жаргалын төлөө эерэг өөрчлөлт гарна гэдэгт итгэж байна" хэмээн илгээлтдээ дурьджээ.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 25
Шөнө 12

Нөгөөдөр
Өдөр 26
Шөнө 11

Өдрийн зурхай

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал: Өчин эмгэг ирнэ
Наран ургах/шингэх: 04:56-20:51



Аргын тооллын 6 сарын 18, Адъяа гараг. Билгийн тооллын 24, Дэлгэрүүлэгч одтой, улаан хулгана өдөр. Өдрийн наран 4 цаг 56 минутад мандан, 20 цаг 51 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, тал, адегуус луулах, лусыг тахиж, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дарханы үйлд сайн. Улааны үйл, толөг тавих, торь уралах, сэтгэлд сэтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, торь, бич, тахиа болой. Хол газар яваар зүүн зүгт одогсод төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДУУЛГАХ СОНИН

Г.Ариунбаатар дэлхийн ЭНТЭЙ дуучин гэдгээ БАТАТГАЛАА



Их Британийн Уэльсийн нийслэл Кардиф хотод хоёр жил тутамд дуурийн дуучдын "BBC Cardiff Singer of the World" тэмцээн болдог. Тэгвэл энэ жил тус тэмцээнд "Чингис хаан" одонт, МУГЖ Г.Ариунбаатар эх орноо төлөөлөн оролцож, "The Song Prize" төрөлд тэргүүн байр эзэлжээ. Тэрбээр, энэ тэмцээнд Шуберт, Чайковский, Форе болон хөгжмийн зохиолч Шаравын уран бүтээлүүдийн дээжээс хүргэсэн байна. Манай дуучин "The Song Prize" төрөлд Америкийн Жон Чест, Шотландын Катриона Морисон, Украины Юрий Самойлов, Английн Луис Алдер нартай өрсөлджээ. Г.Ариунбаатар өөрийн фэйсбүүк хуудаснаа "BBC Cardiff Singer of the World-2017 тэмцээний Романсын төрөлд тэргүүн байр эзэллээ. Энэхүү финалыг миний дуулсан бүтээлүүдээс Б.Шарав багшийн "Монголын тал нутаг" дуугаар өндөрлүүлээ. Дууны үг, аялууг BBC телевизийн хөтлөгч шагшин магтаж, сэтгэл нь хөдлөн нулимс дуслуулж байхыг харах сайхан байлаа. Маргааш сүүлийн Финалтай! Хичээнэ ээ" хэмээн сэтгэгдлээ хуваалцжээ. Баритон хоолойтой МУГЖ Г. Ариунбаатар 2005- 2010 оны хооронд профессор МУГЖ О.Ичинхорлоогийн удирдлага дор суралцсан бөгөөд Москвад болсон М. Глинкийн нэрэмжит олон улсын уралдаанд түрүүлж байв.

ОДДЫН АМЬДРАЛ

Бейонсе ихэр хүүхдээ төрүүлээ

АНУ-ын хөгжмийн ертөнцийн хүчирхэг хосын нэг яах аргагүй дуучин Бейонсе, Жэй Зи нар билээ. Тэгвэл хосууд саяхан хоёр гишүүнээр бүл нэмжээ. Дуучин бүсгүй өнгөрсөгч нүрвэ гарагт Лос-Анжелес хотын эмнэлэгт амаржиж, ихрүүдээ төрүүлсэн байна. Хосууд нэг хүүхэдтэй бөгөөд Бью Айви эдүгээ таван настай юм. Харин ихрүүд мэндэлснээр Жэй Зигийнх ам бул тавуулаа болж байна. Хүүхдийн хүйс одоогоор тодорхойгүй байгаа. Гэхдээ хосуудад баяр хүргэсэн хүмүүсийн сонгосон бэлэгт голдуу эрэгтэй, эмэгтэй хүүхдийг бэлгэдсэн цэнхэр, ягаан өнгө зонхилж байгаа гэнэ.



Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД

Sayaа Sayka

1996 онд охиноо төрүүлээд эмнэлэгт хэвтэж байтал манай төгсөлтийн таньдаг бүсгүй ч бас тэнд төрж таарлаа. Тэгээд тэр дөнгөж төрчихөөд орж ирмэгцээ "чамд бохь бая уу" гэлээ. Би ч айгаад төрсөний дараа сав нь хөөрөөд солирдог гэж сонссон болохоор "Бохь байхгүй" л гэв. Тэгээд бохиор яах гэж бгаа юм гэсэн чинь "Миний доод үүдэн шүдний нэг нь уначихсан юм. Бохь зажилж байгаад бөглөдөг юм аа. Сая төрөх гээд өвдөж байхдаа алга болгочихлоо" гэж үү. кккк

УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цуа, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлаат анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танад:

- Ган болон мөнгөн зүү, шалнагаан зүү
- Хануур, сам соруул
- Шарлага
- Бумба төвөг засал
- Халуун чулуу, давсан халуун жин засал
- Эмчилгээний цэгэн бариа
- Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлаат анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ

Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/